*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 8 дугаар хавсралт*

# ГЕОДЕЗИЙН БАГАЖ БАТАЛГААЖУУЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Д.АЛТАНТУУЛЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: **Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар**
Нэгжийн нэр: **Геодези, зураг зүйн хэлтэс**

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. “Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах”** | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1. (1.4.1.1) Геодези, зураг зүйн чиглэлээр хийх ажлын төсвийн тооцоо | 60 | 10 | 70 | |
| 2 | Арга хэмжээ 1.2. (1.6.1.1) “Геодезийн хэмжлийн багаж шалгах, тохируулах, нарийвчлалыг турших, баталгаажуулах үйл ажиллагааг өргөжүүлэх” ТЭЗҮ | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 2. “Хууль тогтоомж сурталчлах”** | | | | | |
| 3 | Арга хэмжээ 2.1. (2.4.1.1) Шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, стандартыг албан хаагчдад мэдээллэх, олон нийтэд сурталчлах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 3. Геодезийн хэмжих хэрэгслийг шалгах, баталгаажуулах** | | | | | |
| 4 | Арга хэмжээ 3.1. (2.5.1.1) Дунд болон техникийн нарийвчлалтай геодезийн хэмжих хэрэгсэл шалгаж, баталгаажуулах сорилт, туршилт явуулах “Жишилтийн полигон” байгуулах | 42 | 7 | 49 | |
| 5 | Арга хэмжээ 3.2. (2.5.1.2) Тоон нивелир худалдан авах (Инвар рейк, бусад дагалдах иж бүрдлийн хамт) | 60 | 10 | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | Арга хэмжээ 3.3.<br>(2.5.1.3)<br>Геодезийн хэмжил зүйн лабораторийн итгэмжлэл сунгуулах | 60 | 10 | 70 | |
| 7 | Арга хэмжээ 3.4.<br>(2.5.1.4)<br>Жижиг оврын коллиматорын цилиндр тэгш ус солих ажлыг зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| 8 | Арга хэмжээ 3.5.<br>(2.5.1.5)<br>Зай хэмжлийн жишилтийн полигоны 9 багана хоорондын зайг тодорхойлох өвөл, зуны улирлын хэмжилт гүйцэтгэх | 60 | 10 | 70 | |
| 9 | Арга хэмжээ 3.6.<br>(2.5.1.6)<br>Улсын хэмжээнд хэрэглэгдэж буй геодезийн хэмжих хэрэгслийг шалгаж, баталгаажуулах | 60 | 10 | 70 | |
| 10 | Арга хэмжээ 3.7.<br>(2.5.1.7)<br>Жишилтийн полигон дээр геодезийн хэмжих хэрэгслийг шалган хэмжилтийн үр дүнг боловсруулах баталгаажуулах | 60 | 10 | 70 | |
| 11 | Арга хэмжээ 3.8.<br>(2.5.1.8)<br>Аймгуудын ГХБХБГ, нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хэрэглэгдэж буй геодезийн хэмжих хэрэгслийг шалгаж, баталгаажуулах | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 4. 1:1000-ны масштабтай тоон дэвсгэр зургийг шинээр гүйцэтгэх** | | | | | |
| 12 | Арга хэмжээ 4.1.<br>(2.6.1.2)<br>Бусад байгууллагын захиалгаар хийгдсэн геодези, зураг зүйн ажлыг шалгаж хүлээн авах | | | – | |
| **Зорилт 5. GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын сүлжээг өтгөрүүлэх, техник хангамж болон програм хангамжийн шинэчлэлтийг хийж нэгдсэн удирдлагын системд холбох** | | | | | |
| 13 | Арга хэмжээ 5.1.<br>(2.6.2.5)<br>Газрын зургийн систем боловсруулах ТЭЗҮ боловсруулахад санал өгч, хамтран ажиллах | | | – | |
| **Зорилт 6. Геодези, зураг зүйн тухай хуулийн төслийг боловсруулж батлуулах** | | | | | |
| 14 | Арга хэмжээ 6.1.<br>(3.3.1.1)<br>Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг холбогдох хурлаар хэлэлцүүлэхэд шаардлагатай баримт мэдээллээр хангах | | | – | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 15 | Арга хэмжээ 6.2.<br>(3.3.1.2)<br>Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг олон нийтэд хэлэлцүүлэх | | | - | |
| **Зорилт 7. Геодези, зураг зүйн дүрэм, журам, батлуулах** | | | | | |
| 16 | Арга хэмжээ 7.1.<br>(3.4.1.2)<br>"Геодезийн хэмжих хэрэгслийн загвар турших, баталгаажуулах журам"-ын төслийг боловсруулах | 60 | 10 | 70 | |
| 17 | Арга хэмжээ 7.2.<br>(3.4.1.3)<br>Лабораторийн "Чанарын гарын авлага"-ын журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулах, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актад бүртгүүлэх | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 8. Салбарын хууль тогтоомж шинэчлэн батлагдахтай холбогдуулан шаардлагатай эрх зүйн бусад актыг шинэчлэн боловсруулах, батлуулах** | | | | | |
| 18 | Арга хэмжээ 8.1.<br>(3.7.2.1)<br>Салбарын хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулах, санал өгөх, батлуулах ажлыг зохион байгуулах | | | - | |
| **Зорилт 9. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ** | | | | | |
| 19 | Арга хэмжээ 9.1.<br>(4.1.1)<br>Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах | 60 | 10 | 70 | |
| 20 | Арга хэмжээ 9.2.<br>(4.1.2)<br>Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх | 60 | 10 | 70 | |
| 21 | Арга хэмжээ 9.3.<br>(4.1.3)<br>Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах | 60 | 10 | 70 | |
| 22 | Арга хэмжээ 9.4.<br>(4.1.4)<br>Хугацаатай албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах | 60 | 10 | 70 | |
| 23 | Арга хэмжээ 9.5.<br>(4.1.5)<br>Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх | 60 | 10 | 70 | |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 1 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1.<br>Лаборбаторийн "Ажилтны журам"-ыг боловсруулж, батлуулах | 60 | 10 | 70 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Шалгалт баталгаажуулалтын гэрчилгээнд ашигласан арга аргачлалын талаар мэдээлэл оруулах | 60 | 10 | 70 | |
| 3 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Итгэмжлэлийн хамрах хүрээнд EDM-ийн зайн хэмжлийн хамрах хүрээг нэмж оруулах | 60 | 10 | 70 | |
| 4 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Геодезийн хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийхэд гүйцэтгэхэд орчны температур, чийг даралтын нөлөө /даралт, температур/ тооцох шаардлагатай. Иймд эдгээр нөхцлийг хянах бүртгэх баталгаатай хэмжих хэрэгсэл дутмаг байна. Нэг хэмжих хэрэгсэл байгаа боловч шалгалт тохируулгад хамрагдаагүй. | 60 | 10 | 70 | |
| 5 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. Дотоодын лаборатори хоорондын харьцуулалт зохион байгуулах | 60 | 10 | 70 | |
| **Дундаж оноо:** | | | | 69.0 | |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуул, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Арга хэмжээ 2.1<br>Хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | | 15 | |
| 2 | Арга хэмжээ 2.2<br>Олон улсын харьцуулалтад оролцох бэлтгэл ажил | | 15 | |
| **Дундаж оноо** | | | 15 | |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

| д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 6 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 7 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |

| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
|---|---|---|---|
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | 7 | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | | |
| **Дундаж оноо** | | 6.8 | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7.7 |
| 2. | Багаар ажиллах | 7.3 |
| 3. | Харилцаа | 7.3 |
| **Дундаж оноо** | | 7.4 |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | 69 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | 6.8 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 7.4 |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | -2 |
| **Нийт оноо =** ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 98.2<br>96.2 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА ......Д. Мөнхцэцэг...... Д.МӨНХЦЭЦЭГ

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

ГЕОДЕЗИЙН БАГАЖ БАТАЛГААЖУУЛАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ............................ Д.АЛТАНТУУЛ

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

ТЗУГ-ын дарга ................ /Б.Энхболд/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.05.09 *(огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

ТЗУГ-ын ахлах мэргэжилтэн ................ /М.Сумъяабазар/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.05.07 *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч***

ГАЗРЫН ДАРГА ................/ А.ЭНХМАНЛАЙ

# ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ХЭЛТСИЙН ГЕОДЕЗИЙН БАГАЖ БАТАЛГААЖУУЛАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Д.АЛТАНТУУЛЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| **Зорилт 1. “Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах”** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1. (1.4.1.1) Геодези, зураг зүйн чиглэлээр хийх ажлын төсвийн тооцоо | Үйл ажиллагаа | Геодези, зураг зүйн чиглэлээр 2025 онд хийх ажлын төсвийн тооцоог 2024 онд гаргаж СЭЗХ-т хүргүүлсэн. | **Эхний хагас жилд:** Геодези, зураг зүйн чиглэлээр хийх ажлын үндэслэл, хэрэгцээ, шаардлага, төсвийн тооцоо гаргаж, 2026 оны төсөвт тусгуулахаар ЗГХЭГ-т хүргүүлнэ. | Эталон коллиматорын нарийвчлалыг сайжруулж, шинэчлэхэд шаардлагатай төсвийн тооцоог гаргаж, 2026 оны төсөвт тусгуулахаар 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | 01.02-06.30 | 100 |
| 2 | Арга хэмжээ 1.2. (1.6.1.1) “Геодезийн хэмжлийн багаж шалгах, тохируулах, нарийвчлалыг турших, баталгаажуулах үйл ажиллагаа өргөжүүлэх” ТЭЗҮ | 1 Техник, эдийн засгийн үндэслэл | - | **Эхний хагас жилд:** Геодезийн хэмжих хэрэгсэл шалгах, тохируулах, нарийвчлалыг турших, баталгаажуулах үйл ажиллагаа өргөжүүлэх ТЭЗҮ-ийн судалгаа, тооцоог гаргана. **Сүүлийн хагас жилд:** Геодезийн хэмжих хэрэгсэл шалгах, тохируулах, нарийвчлалыг турших, баталгаажуулах үйл ажиллагаа өргөжүүлэх ТЭЗҮ-ийг боловсруулна. | Геодезийн хэмжлийн үйл ажиллагаанд ашигладаг Дунд болон техникийн нарийвчлалтай хэмжих хэрэгсэл шалгах, баталгаажуулах полигон шинээр байгуулах төсөв, байгууламжийн зураг, ажлын даалгаврын төсөл боловсруулж, 2025 оны 03 дугаар сарын 07-ны Газрын даргаар батлуулсан. Агаарын зургийн тоон камер болон Гравиметрийн багаж шалгах, баталгаажуулах 2 полигоныг сэргээн засварлахад шаардлагатай ажлын төсвийг хийж саналаа холбогдох нэгжид хүргүүлсэн. | 01.02-06.30 | 100 |
| **Зорилт 2. “Хууль тогтоомж сурталчлах”** | | | | | | | |
| 3 | Арга хэмжээ 2.1. (2.4.1.1) Шинээр батлагдсан хууль, дүрэм, журам, стандартыг | Сургалтын тоо Хамрагдсан иргэн, хуулийн | 5 удаагийн сургалт, мэдээллийн цагийг зохион байгуулсан. | **Эхний хагас жилд:** Геодези, зураг зүйн салбарт шинээр болон шинэчлэн батлагдсан эрх зүйн баримт бичгийг салбарын | 21 аймгийн ГХБХБГ, Нийслэлийн ГЗБА-ны ГЗЗ-н асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд 2025 оны 04 дүгээр сарын 30-аас 05 дугаар сарын 01-ний өдөр сургалт зохион байгуулав. | 01.02-06.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | албан хаагчдад мэдээллэх, олон нийтэд сурталчлах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах | этгээдийн тоо | | мэргэжилтнүүд, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэх, танилцуулах сургалтыг зохион байгуулсан байна.<br>**Сүүлийн хагас жилд:**<br>Геодези, зураг зүйн салбарт шинээр болон шинэчлэн батлагдсан эрх зүйн баримт бичгийг салбарын мэргэжилтнүүд, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэх, танилцуулах сургалтыг зохион байгуулсан байна. | Сургалтаар геодезийн хэмжих хэрэгслийн нарийвчлал, загвар турших, үр дүнг баталгаажуулах, бүртгэх дэд систем, лабораторийн үйл ажиллагаанд мөрдөн хэрэгжүүлэн ажилладаг "Чанарын гарын авлага"-д нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан шинээр баталсан "Ажилтны журам", Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд геодезийн хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтаар ямар зүйл заалт орсон талаар мэдээлэл хийсэн.<br>Мөн 21 аймгийн ГХБХБГазарт хэмжлийн үйл ажиллагаанд ашигладаг геодезийн хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагааг хангуулах зорилгоор 2025 онд хийсэн судалгаанд суурилсан хэрэгцээ шаардлагад нийцүүлэн зөвлөмж, холбогдох мэдээллийг хүргэсэн. | | |
| **Зорилт 3. Геодезийн хэмжих хэрэгслийг шалгах, баталгаажуулах** | | | | | | | |
| 4 | Арга хэмжээ 3.1. (2.5.1.1) Дунд болон техникийн нарийвчлалтай геодезийн хэмжих хэрэгсэл шалгаж, баталгаажуулах сорилт, туршилт явуулах "Жишилтийн полигон" байгуулах | 1 полигон | Төв аймгийн Номтын аманд байрлах "Жишилтийн полигон"-д геодезийн хэмжих хэрэгслийг баталгаажуулдаг. | **Эхний хагас жилд:**<br>Дунд болон техникийн нарийвчлалтай геодезийн хэмжих хэрэгсэл шалгаж, баталгаажуулах, сорилт, туршилт явуулах "Жишилтийн полигон"-ы байгууламжийн зураг, төсөв хийх, ажлын даалгавар боловсруулж, батлуулна. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажлыг эхлүүлнэ.<br>**Сүүлийн хагас жилд:**<br>Дунд болон техникийн нарийвчлалтай геодезийн хэмжих хэрэгсэл шалгаж, | Геодезийн хэмжил зүйн лабораторийн үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд "Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-нд заасны дагуу геодезийн хэмжил зүйн лабораторийн дунд болон техникийн нарийвчлалтай геодезийн хэмжих хэрэгсэл шалгах, баталгаажуулах полигон байгуулах ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн зарлалыг 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны | 01.02-06.30 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | баталгаажуулах, сорилт, туршилт явуулах “Жишилтийн полигон”-ыг хүлээн авч, хэвийн үйл ажиллагааг хангана. | www.tender.gov.mn цахим системд зарлаж, амжилтгүй болсон.<br>Тендерийг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр дахин зарлан 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр нээсэн ба тендерт 2 хуулийн этгээд оролцож Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалтад заасны дагуу “Геосет” ХХК нь “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендерээр шалгарсан тул гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 1/1423 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>Гэвч тус компаниас гэрээт ажлын санхүүжилт хүрэлцэхгүй, нэмэлт санхүүжилт хүссэн тухай 2025 оны 49/25 дугаартай албан бичиг ирүүлсэн байна. Тус газраас нэмэлт санхүүжилт олгох боломжгүй, 28,200,000 төгрөгөөр дээрх ажлыг гүйцэтгэх эсэх шийдвэрээ ирүүлэх тухай 2025 оны 1/1781 дугаар албан бичгийг хүргүүлсэн. Тендерт шалгарсан “Геосет” ХХК-иас 2025 оны 55/25 дугаар албан бичгээр дээрх ажлыг гүйцэтгэх боломжгүй шийдвэрээ эргэн мэдэгдсэн тул tender.gov.mn цахим системд оруулсан үр дүнг цуцалж, 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр www.tender.gov.mn цахим системд тендерийг дахин зарласан.<br>Тендерийг 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр нээхэд нэг ч оролцогч ирээгүй тул тендер амжилтгүй болсон. Геодезийн үйлдвэр, үйлчилгээ эрхлэн явуулах тусгай | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөвшөөрөлтэй "Некст Жи Ай Эс" ХХК-тай зөвшилцөж гүйцэтгүүлэхээр захиалагчид зөвлөмж хүргүүлэв. | | |
| 5 | Арга хэмжээ 3.2. (2.5.1.2) Тоон нивелир худалдан авах (Инвар рейк, бусад дагалдах иж бүрдлийн хамт) | 1 багаж | Лабораторид шалгалт тохируулгад одоо ашиглаж буй эталон автомат нивелир 1км нүүлтийн дундаж квадрат алдаа 1.0мм нарийвчлалтай ба лабораториор шалгалт, тохируулга хийлгэхээр ирж буй хэмжих хэрэгслүүд 0.3мм-ээс дээш өндөр нарийвчлалтай байдаг. | **Эхний хагас жилд:**<br>Тоон нивелир (Инвар рейк, бусад дагалдах иж бүрдлийн хамт) худалдан авах ажлын даалгавар боловсруулж, батлуулна. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, нийлүүлэх ажлыг эхлүүлнэ.<br>**Сүүлийн хагас жилд:**<br>Лабораторид өндөр нарийвчлалын эталон тоон нивелирийг шалгалт, тохируулгын үйл ажиллагаанд ашиглана. | Лабораторийн том, дунд, жижиг оврын коллиматорын шалгалт тохируулгад ашигладаг эталон багажны нарийвчлалыг сайжруулахаар Геодезийн хэмжил зүйн лабораторийн багаж баталгаажуулалтад шаардлагатай багаж худалдан авах (Тоон нивелир) тендерийн зарлалыг 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд ажлын 10 хоногийн хугацаатай нийтэлж, тендерийн нээлтийг 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 14 цаг 30 минутад нээж, хамгийн сайн тендер ирүүлсэн "Инженер геодези" ХХК шалгарч 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр 2025/36 дугаар гэрээ байгуулсан.<br>Гэрээнд заасны дагуу тоон нивелир, бусад дагалдах хэрэгслийг техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагын дагуу гэрээ дүгнэсэн актаар 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр хүлээн авсан. | 01.02-06.30 | 100 |
| 6 | Арга хэмжээ 3.3. (2.5.1.3) Геодезийн хэмжил зүйн лабораторийн итгэмжлэл сунгуулах | Үйл ажиллагаа | 2022 онд Геодезийн хэмжил зүйн лаборатори магадлан итгэмжлэгдсэн. | MNS ISO/IEC 17025:2018 стандарт "Сорилтын болон шалгалт, тохируулгын лабораторийн чадавхид тавигдах ерөнхий шаардлага"-д нийцүүлэн геодезийн хэмжил зүйн лабораторийн итгэмжлэл сунгуулах хүсэлт, холбогдох материалын хамт Үндэсний | Лабораторийг MNS ISO/IEC 17025:2018 "Сорилтын болон шалгалт, тохируулгын лабораторийн чадавхид тавигдах ерөнхий шаардлага" стандартын дагуу давтан итгэмжлүүлэхээр Үндэсний итгэмжлэлийн төвд 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 1\2516 дугаар албан бичгийг хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, | 01.02-06.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | итгэмжлэлийн төвд хүргүүлэх, итгэмжлэл авна. | баталгаажуулалтын лабораторийг итгэмжлүүлэх хүсэлт гаргах маягт, үнэлгээний шалгах хуудас, холбогдох материалын хамт хүргүүлсэн.<br>Тус төвөөс тохирлын үнэлгээний байгууллагад итгэмжлэлийн үнэлгээний багийн бүрэлдэхүүнийг танилцуулж, санал авахаар мэдэгдэл илгээсэн.<br>Саналаа 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдөр www.s.gandul@mnas.gov.mn хаягаар илгээсэн.<br>Лабораторид 2025 оны 03 дугаар сарын 31-нээс 04 дүгээр сарын 01-ний өдрүүдэд Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/65 дугаар тушаалын хавсралтаар баталсан үнэлгээний ажлын хэсэг дараах 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажилласан.<br>Үүнд:<br>1. Ц.Алтанцэцэг<br>(Ажлын хэсгийн ахлагч, "Метролаб сивил консалтинг" ХХК-ийн захирал, Үндэсний итгэмжлэлийн төвийн гэрээт шинжээч);<br>2. Б.Болормаа<br>("Баясах сурвэй" ХХК, Геодезийн инженер);<br>Үнэлгээг MNS ISO/IEC 17025:2018 "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих шаардлага" стандарт, үндэсний итгэмжлэлийн төвийн бодлогын баримт бичиг, холбогдох итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хангаж байгаа эсэхэд үнэлгээ хийж, дүгнэлт гаргасан.<br>Магадлан итгэмжлэлийн үнэлгээний хаалтын ажиллагааны тайлангийн хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Засгийн газрын XII байрны 205 тоот хурлын танхимд зохион байгуулсан.<br>Хурлаар итгэмжлэлийн үнэлгээний ажлын хэсгээс дараах 3-н үл тохирол, 7-н зөвлөмжийг өгсөн. Үүнд:<br><u>Үл тохирол:</u><br>1. Ажилтны журам боловсруулж, Газрын даргаар батлуулах (MNS ISO/IEC 17025:2018 стандартын 6.2.5-т заасны дагуу);<br>2. Тоног төхөөрөмжийн бүртгэлд мэдээллийг бүрэн оруулах (MNS ISO/IEC 17025:2018 стандартын 6.4.13-т заасны дагуу);<br>3. Шалгалт баталгаажуулалтын гэрчилгээнд ашигласан арга аргачлалын талаар мэдээлэл оруулах (MNS ISO/IEC 17025:2018 стандартын 7.8.2.1-т заасны дагуу);<br><u>Зөвлөмж:</u><br>1. Хэмжлийн эргэлзээг тооцоолдог болох;<br>2. Харьцуулалтын хэмжлийн үр дүнд анализ хийж зохих шалгуурт нийцэж байгаа эсэхийг тогтоох, лаборатори доторх харьцуулалт хийх – Үр дүнгийн үнэн бодит байдлыг хангах;<br>3. Тоног төхөөрөмжийн техник ашиглалтын паспортын хөтлөлтийг сайжруулах; | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 4. Коллиматорын шалгалт тохируулга хийсэн бүртгэлдээ зөвшөөрөгдөх утгыг нэмж оруулан харьцуулах;<br>5. Гэрчилгээ болон бусад баримт бичиг дээр хэмжлийн нэгжийг тодорхой бичиж оруулах;<br>6. Итгэмжлэлийн хамрах хүрээнд EDM-ийн зайн хэмжлийн хамрах хүрээг нэмж оруулах;<br>7. Геодезийн хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийхэд гүйцэтгэхэд орчны температур, чийг даралтын нөлөө /даралт, температур/ тооцох шаардлагатай. Иймд эдгээр нөхцлийг хянах бүртгэх баталгаатай хэмжих хэрэгсэл дутмаг байна. Нэг хэмжих хэрэгсэл байгаа боловч шалгалт тохируулгад хамрагдаагүй. (MNS ISO/IEC 17025:2018 стандартын 6.3.5-т заасны дагуу);<br>Дээрх илэрсэн үл тохирол, зөвлөмжийг залруулах ажлын төлөвлөгөө боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Газрын даргаар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу үл тохирол, зөвлөмжийг залруулан 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр 1/1518 дугаар албан бичгээр үнэлгээний ажлын хэсэг, итгэмжлэлийн үндэсний төвд хүргүүлсэн.<br>Үндэсний итгэмжлэлийн төвийн техникийн хорооны 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар үнэлгээний ажлын хэсгийн гаргасан тайланг хэлэлцүүлэн 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 4 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | жилийн хугацаатайгаар TL-V буюу шалгалт баталгаажуулалтаар давтан итгэмжлэлийг сунгахаар шийдвэрлэсэн. | | |
| 7 | Арга хэмжээ 3.4. (2.5.1.4) Жижиг оврын коллиматорын цилиндр тэгш ус солих ажлыг зохион байгуулах | 2 цилиндр тэгш ус | 2013 оноос хойш урсгал засвар хийгдээгүй. | **Эхний хагас жилд:**<br>Жижиг оврын коллиматорын 2 цилиндр тэгш усыг худалдан авах үнийн судалгаа хийж, солих ажлыг зохион байгуулна. | Геодезийн хэмжлийн багаж хэрэгсэл шалгаж тохируулах зориулалттай БНХАУ-д үйлдвэрлэсэн NCS-1 маркийн жижиг оврын коллиматорын 2 ширхэг цилиндр тэгш усыг сольж хэвийн ажиллагааг хангасан. | 01.02-06.30 | 100 |
| 8 | Арга хэмжээ 3.5. (2.5.1.5) Зай хэмжлийн жишилтийн полигоны 9 багана хоорондын зайг тодорхойлох өвөл, зуны улирлын хэмжилт гүйцэтгэх | 2 багц хэмжилт | Төв аймгийн Номтын аманд байрлах Зай хэмжлийн жишилтийн полигоны багана хоорондын зайг 2009-2024 онд хийсэн. | **Эхний хагас жилд:**<br>Төв аймгийн Номтын аманд байрлах Зай хэмжлийн жишилтийн полигоны 9 багана хоорондын зайг өндөр нарийвчлалтай хэмжих хэрэгслээр өвлийн улирлын хэмжилтийг гүйцэтгэж, үр дүнг боловсруулсан байна.<br>**Сүүлийн хагас жилд:**<br>Төв аймгийн Номтын аманд байрлах Зай хэмжлийн жишилтийн полигоны 9 багана хоорондын зайг өндөр нарийвчлалтай хэмжих хэрэгслээр зуны улирлын хэмжилтийг гүйцэтгэж, үр дүнг боловсруулж, нэгтгэн тайлагнасан байна. | Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан "Өвлийн улирлын хэмжилтийн албан томилолтын удирдамж"-ийн дагуу Зай хэмжлийн жишилтийн полигоны 9 багана хоорондын зайг өндөр нарийвчлалтай электрон тахеометрээр тодорхойлох харьцуулсан хэмжилтийг Иргэний нисэхийн ерөнхий газрын Оншилгоо, хэмжил зүйн лаборатори, "Геосурвэй" ХХК-тай хамтран 2025 оны 01 дүгээр сарын 27-30-ны өдрүүдэд Төв аймгийн Номтын аманд байрлах "Зай хэмжлийн жишилтийн полигон"-нд MNS ISO/IEC 17123-4:2016 стандарт "Зай хэмжлийн багажинд шалгалт хийх заавар"-ын дагуу гүйцэтгэсэн.<br>Хэмжилтэд Sokkia фирмийн NET05AX маркийн өнцгийн 0.5 секунд, зай хэмжлийн 0.8 мм+1ppm, Topcon фирмийн OS101 маркийн өнцгийн 1 секунд, зай хэмжлийн 1.5 мм+2ppm, Trimble фирмийн S7 маркийн өнцгийн 1 секунд, зай хэмжлийн 1мм+2ppm тус тус нарийвчлалтай 3 электрон тахеометрийг ашигласан. | 01.02-06.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Үр дүнг MNS ISO/IEC 17123 цуврал стандартын 4 дүгээр бүлэгт заасны дагуу боловсруулсан. | | |
| 9 | Арга хэмжээ 3.6. (2.5.1.6) Улсын хэмжээнд хэрэглэгдэж буй геодезийн хэмжих хэрэгслийг шалгаж, баталгаажуулах | 600 хэмжих хэрэгслийн шалгалт, баталгаажуулалт | 2024 онд 920 гаруй иргэн, аж ахуйн нэгж, иргэний 1116 хэмжих хэрэгсэлд шалгалт, тохируулга хийж баталгаажуулсан. | **Эхний хагас жилд:**<br>Геодезийн хэмжлийн 300 хэмжих хэрэгсэлд шалгалт, баталгаажуулалт хийж, гэрчилгээ олгон бүртгэлийг мэдээллийн санд оруулсан байна.<br>**Сүүлийн хагас жилд:**<br>Геодезийн хэмжлийн 300 хэмжих хэрэгсэлд шалгалт, баталгаажуулалт хийж, гэрчилгээ олгон бүртгэлийг мэдээллийн санд оруулсан байна. | Геодезийн хэмжил зүйн лаборатори эхний хагас жилийн байдлаар геодезийн хэмжих хэрэгслийн хэмжлийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор бүх төрлийн хэмжилт, зураглалын ажилд ашиглаж буй геодезийн хэмжлийн 665 хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга, баталгаажуулалт хийж, 41,057,000 төгрөгийн орлого улсын төсөвт оруулсан.<br>Үүнээс лабораторийн нөхцөлд том, дунд, жижиг оврын коллиматорыг ашиглан автомат нивелир-168ш, тоон нивелир-31ш, электрон тахеометр-75ш, электрон теодолит-43ш, лазер хэмжигч-8ш, нийт 325 геодезийн хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийж 19,707,360 төгрөгийн орлого улсын төсөвт оруулсан. | 01.02-06.30 | 100 |
| 10 | Арга хэмжээ 3.7. (2.5.1.7) Жишилтийн полигон дээр геодезийн хэмжих хэрэгслийг шалган хэмжилтийн үр дүнг боловсруулах баталгаажуулах | 500 GNSS-ийн хүлээн авагч баталгаажуулах Мэдээллийн сан хөтлөх | 2024 онд 881 GNSS-ийн хүлээн авагчийг шалгаж, баталгаажуулсан. | **Эхний хагас жилд:**<br>Геодезийн хэмжлийн 250 GNSS-ийн хүлээн авагч шалган баталгаажуулж, гэрчилгээ олгон бүртгэлийг мэдээллийн санд оруулсан байна.<br>**Сүүлийн хагас жилд:**<br>Геодезийн хэмжлийн 250 GNSS-ийн хүлээн авагч шалган баталгаажуулж, гэрчилгээ олгон бүртгэлийг мэдээллийн санд оруулсан байна. | Геодезийн хэмжил зүйн лаборатори эхний хагас жилийн байдлаар геодезийн хэмжих хэрэгслийн хэмжлийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор бүх төрлийн хэмжилт, зураглалын ажилд ашиглаж буй геодезийн хэмжлийн 510 хүлээн авагчид шалгалт баталгаажуулалт хийж, 37,071,000 төгрөгийн орлого улсын төсөвт оруулсан.<br>Үүнээс Төв аймгийн Номтын аманд байрлах "Жишилтийн полигон"-д геодезийн хэмжлийн GNSS-ийн 257 хүлээн авагчийн хэмжилтийн өгөгдлийг шалгаж баталгаажуулан багаж бүртгэлийн цахим системийн | 01.02-06.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээллийн санд давхцалыг шүүж, бүртгэл хөтлөн, шаардлагатай нэмэлт мэдээллийг оруулан гэрчилгээ олгон 19,483,000 төгрөгийн орлогыг улсын төсөвт оруулсан. | | |
| 11 | Арга хэмжээ 3.8. (2.5.1.8) Аймгуудын ГХБХБГ, нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хэрэглэгдэж буй геодезийн хэмжих хэрэгслийг шалгаж, баталгаажуулах | 40 багажны шалгалт, баталгаажуулалт хийж мэдээллийн сан хөтлөх /Аймгууд электрон тахеометр, нивелирээ акталсан учир өмнөх оны хэмжээнээс тоо буурсан../ | 2024 онд 21 аймгийн ГХБХБГ, нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хэрэглэж байгаа нийт 60 хэмжих хэрэгсэлд шалгалт, тохируулга хийж баталгаажуулсан. | **Эхний хагас жилд:** Аймгийн ГХБХБГазарт хэрэглэгдэж байгаа геодезийн хэмжлийн 15 хэмжих хэрэгсэлд шалгалт, баталгаажуулалт хийж, гэрчилгээ олгон бүртгэлийг мэдээллийн санд оруулсан байна. **Сүүлийн хагас жилд:** Аймгийн ГХБХБГазарт хэрэглэгдэж байгаа геодезийн хэмжлийн 25 хэмжих хэрэгсэлд шалгалт, баталгаажуулалт хийж, гэрчилгээ олгон бүртгэлийг мэдээллийн санд оруулсан байна. | Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Говьсүмбэр, Дорноговь, Баянхонгор, Орхон зэрэг 4 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хэрэглэгдэж буй геодезийн бүх төрлийн өндөр, байрлал, өнцөг, зай хэмжлийн 16 хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалган хүлээн авч, баталгаажуулан, багаж бүртгэлийн цахим системийн мэдээллийн санд бүртгэж, шаардлагатай нэмэлт мэдээллийг оруулан, гэрчилгээ олгосон. | 01.02-06.30 | 100 |
| **Зорилт 4. 1:1000-ны масштабтай тоон дэвсгэр зургийг шинээр гүйцэтгэх** | | | | | | | |
| 12 | Арга хэмжээ 4.1. (2.6.1.2) Бусад байгууллагын захиалгаар хийгдсэн геодези, зураг зүйн ажлыг шалгаж хүлээн авах | Геодези, зураг зүйн ажлын үр дүн ирүүлсэн хүсэлтийн тоогоор | 2024 онд ААН-ийн ирүүлсэн хүсэлтэд хяналт хийж, дүгнэлтээр Геодези, зураг зүйн улсын нэгдсэн санд хүлээлгэн өгсөн. | **Эхний хагас жилд:** Хүсэлт ирсэн тухай бүрд ажлыг шалгаж, үр дүнг Геодези, зураг зүйн улсын нэгдсэн санд хүлээлгэн өгсөн. байна. **Сүүлийн хагас жилд:** Хүсэлт ирсэн тухай бүрд ажлыг шалгаж, үр дүнг Геодези, зураг зүйн улсын нэгдсэн санд хүлээлгэн өгсөн. байна. | - | 01.02-06.30 | - |
| **Зорилт 5. GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын сүлжээг өтгөрүүлэх, техник хангамж болон програм хангамжийн шинэчлэлтийг хийж нэгдсэн удирдлагын системд холбох** | | | | | | | |
| 13 | Арга хэмжээ 5.1. (2.6.2.5) Газрын зургийн систем боловсруулах ТЭЗҮ боловсруулахад | ТЭЗҮ-1 | Геодези, зураг зүйн удирдлагын нэгдсэн системтэй болсон. Геодезийн хэмжилт, зураглалын багаж | **Эхний хагас жилд:** Геодези, зураг зүйн системийг хөгжүүлэх Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах Ажлын | - | 01.02-06.30 | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | санал өгч, хамтран ажиллах | | баталгаажуулалтын дэд систем хийсэн. | даалгаварт санал өгсөн байна. | | | |
| **Зорилт 6. Геодези, зураг зүйн тухай хуулийн төслийг боловсруулж батлуулах** | | | | | | | |
| 14 | Арга хэмжээ 6.1. (3.3.1.1) Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг холбогдох хурлаар хэлэлцүүлэхэд шаардлагатай баримт мэдээллээр хангах | 1 хуулийн төсөл | Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг ЗГХЭГ-т хүргүүлсэн. | **Эхний хагас жилд:** Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг холбогдох хурлаар хэлэлцүүлэхэд хамтран ажиллах, шаардлагатай баримт мэдээллээр хангана. | - | 01.02-06.30 | – |
| 15 | Арга хэмжээ 6.2. (3.3.1.2) Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг олон нийтэд хэлэлцүүлэх | 1 хуулийн төсөл | Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг 2023 онд олон нийтээр хэлэлцүүлсэн. | **Эхний хагас жилд:** Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэг зохион байгуулах, сурталчлах, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангахад хамтран ажиллана. | - | 01.02-06.30 | – |
| **Зорилт 7. Геодези, зураг зүйн дүрэм, журам, батлуулах** | | | | | | | |
| 16 | Арга хэмжээ 7.1. (3.4.1.2) "Геодезийн хэмжих хэрэгслийн загвар турших, баталгаажуулах журам"-ын төслийг боловсруулах | 1 журам | - | **Эхний хагас жилд:** "Геодезийн хэмжих хэрэгслийн загвар турших, баталгаажуулах журам"-ын төслийг боловсруулсан байна. **Сүүлийн хагас жилд:** "Геодезийн хэмжих хэрэгслийн загвар турших, баталгаажуулах журам"-ын төслийг холбогдох хурлаар хэлэлцүүлж баталсан байна. | Монгол Улсын Хэмжил зүйн тухай хууль, Стандарт, хэмжил зүйн газраас хууль эрхийн хэмжил зүйн олон улсын байгууллага (OIML)-аас гаргасан баримт бичиг, зөвлөмжийн дагуу шинэчлэн боловсруулсан Хэмжих хэрэгсэлд загварын туршилт хийх журам, Хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийх журмыг судалсан. Журмын төслийг геодезийн хэмжих хэрэгслийн нарийвчлал, загварыг турших, үр дүнг баталгаажуулах, бүртгэх дэд системийн | 01.02-06.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөгжүүлэлтийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулсан. | | |
| 17 | Арга хэмжээ 7.2. (3.4.1.3) Лабораторийн "Чанарын гарын авлага"-ын журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулах, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актад бүртгүүлэх | 13 журам | 2024 онд Геодезийн хэмжлийн багаж баталгаажуулах цахим систем ашиглалтад орсон. | **Эхний хагас жилд:** Лабораторийн үйл ажиллагаанд мөрдөг журмуудыг нэмэлт, өөрчлөлт оруулан шинэчлэн батлуулна. | "Баримт бичгийн үзлэгт хийсэн тайлан"-ийн үзлэгээр гаргасан зөвлөмжийг тусган лабораторийн үйл ажиллагаанд мөрддөг "Чанарын гарын авлага"-д нэмэлт өөрчлөлт оруулж Газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/78 дугаар тушаалаар батлуулсан.<br>Лабораторид хийсэн магадлан итгэмжлэлийн үнэлгээгээр "Ажилтны журам"-гүй гэсэн үл нийцэл илэрсэн тул шинээр боловсруулж холбогдох газар, хэлтсүүдээс санал авч тусган 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн Газрын даргын А/122 дугаар тушаалаар баталж, лабораторийн "Чанарын гарын авлага"-д нэмж оруулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан. | 01.02-06.30 | 100 |
| **Зорилт 8. Салбарын хууль тогтоомж шинэчлэн батлагдахтай холбогдуулан шаардлагатай эрх зүйн бусад актыг шинэчлэн боловсруулах, батлуулах** | | | | | | | |
| 18 | Арга хэмжээ 8.1. (3.7.2.1) Салбарын хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулах, санал өгөх, батлуулах ажлыг зохион байгуулах | нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл | - | **Эхний хагас жилд:** Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.<br>**Сүүлийн хагас жилд:** Хуулийн төслийг холбогдох байнгын хороо, УИХ-аар хэлэлцүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж, хуулийн төслийг батлуулахад холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байна. | - | 01.02-06.30 | – |
| **Зорилт 9. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ** | | | | | | | |
| 19 | Арга хэмжээ 9.1. (4.1.1) | Үүрэг даалгаврын тоо | - | **Эхний хагас жилд:** | ГЗБГЗЗЕГ-ын Дотоод арга хэмжээний төлөвлөгөөнд туссан "Монгол цэргийн өдөр"-ийг тэмдэглэн | 01.02-06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Удирдлагаас болон хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, тайлагнах | | | Өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, тухай бүр тайлагнасан байна.<br>**Сүүлийн хагас жилд:**<br>Өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, тухай бүр тайлагнасан байна. | өнгөрүүлэх арга хэмжээг 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан.<br>Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг урьдчилсан байдлаар 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр гаргаж тайлагнав.<br>Эхний хагас жилд нийт 21 удаагийн шуурхайгаас өгөгдсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлж тайлагнасан. | | 100 |
| 20 | Арга хэмжээ 9.2. (4.1.2)<br>Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, тайланг тушаалд заасан хугацаанд холбогдох мэргэжилтэнд хүргүүлэх | Тушаалд заасан хугацаа | - | **Эхний хагас жилд:**<br>Ажлын хэсэгт ажиллаж, хэрэгжилтийг тухай бүр тайлагнасан байна..<br>**Сүүлийн хагас жилд:**<br>Ажлын хэсэгт ажиллаж, хэрэгжилтийг тухай бүр тайлагнасан байна. | 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/106 дугаар тушаалаар байгуулсан багаж хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд ажиллаж, тоон нивелир (Инвар рейк, бусад дагалдах иж бүрдлийн хамт)-ийг техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагын дагуу гэрээ дүгнэсэн актаар баталгаажуулан 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр хүлээн авч, тушаалд заасан хугацаанд хэрэгжилтийн тайлан бичив. | 01.02-06.30 | 100 |
| 21 | Арга хэмжээ 9.3. (4.1.3)<br>Тогтоол шийдвэрийн биелэлт гаргах | Тогтоол, шийдвэрийн тоо | - | **Эхний хагас жилд:**<br>Холбогдогдох тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг хугацаанд нь тайлагнасан байна.<br>**Сүүлийн хагас жилд:**<br>Холбогдогдох тогтоол шийдвэрийн биелэлтийг цаг хугацаанд нь тайлагнасан байна. | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн судалгааны биелэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр гаргаж, ГСШБТГ-т хүргүүлж тайлагнасан.<br>Алсын хараа-2050 урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдөр тайлагнасан. | 01.02-06.30 | 100 |
| 22 | Арга хэмжээ 9.4. (4.1.4)<br>Хугацаатай албан бичиг, өргөдөл | Шийдвэрлэсэн албан бичиг, | - | **Эхний хагас жилд:**<br>Нэгжид ирсэн хугацаатай албан бичиг, өргөдөл гомдлыг | Геодезийн хэмжил зүйн лабораторийн хариуцсан асуудалтай холбоотой иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн 31 албан | 01.02-06.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гомдол шийдвэрлэх, хяналт тавьж ажиллах | өргөдөл, гомдлын тоо | | заасан хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | бичгийг хянаж, холбогдох журмын дагуу шийдвэрлэсэн. | | |
| 23 | Арга хэмжээ 9.5. (4.1.5) Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын баримт бүрдүүлэх, хавтаслах, байгууллагын архивт хүлээлгэн өгөх | Архивт хүлээлгэн өгсөн баримтын тоо | - | **Эхний хагас жилд:** Нэгжийн урьд онд хийсэн ажлын баримт бичгийг тайлант оны эхний улиралд багтаан байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан байна. | Геодезийн хэмжил зүйн лабораторид 2024 онд 1288 хэмжих хэрэгсэлд баталгаажуулалтад хүлээн авах, олгох хуудас бичигдэн Архивт баримт бичиг хүлээлгэн өгөх журамд заасны дагуу баримт бичгийн иж бүрдлийг хангаж байгууллагын архивт 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдөр хүлээлгэн өгсөн. | 01.02-06.30 | 100 |

## Нэмэлт үүрэг даалгавар, арга хэмжээний биелэлт

| д/д | Үүрэг даалгавар | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Арга хэмжээ 1. Ажилтны журам боловсруулж, Газрын даргаар батлуулах | 1 журам | - | MNS ISO/IEC 17025:2018 стандартын 6.2.5-т заасан шаардлагад нийцсэн байна. | MNS ISO/IEC 17025:2018 стандартын 6.2.5-т заасны дагуу “Ажилтны журам”-ын төсөл боовсруулан санал авч холбогдох засварыг хийж, Газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/122 дугаар тушаалаар лабораторийн “Чанарын гарын авлага”-ын хорьдугаар хавсралтаар баталсан.  | 01.02-06.30 | 100 |
| 2 | Арга хэмжээ 3. Шалгалт баталгаажуулалтын гэрчилгээнд ашигласан арга аргачлалын талаар мэдээлэл оруулах | Тус бүр | - | MNS ISO/IEC 17025:2018 стандартын 7.8.2.1-т заасан шаардлагад нийцсэн байна. | MNS ISO/IEC 17025:2018 стандартын 7.8.2.1-т заасны дагуу шалгалт баталгаажуулалтын гэрчилгээнд геодезийн хэмжих хэрэгсэл тус бүр дээр олгогдох гэрчилгээний тусгай тэмдэглэл хэсэгт ашигласан стандарт, арга аргачлалын мэдээллийг нэмж оруулсан. | 01.02-06.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | |   | | |
| 3 | Арга хэмжээ 6. Итгэмжлэлийн хамрах хүрээнд EDM-ийн зайн хэмжлийн хамрах хүрээг нэмж оруулах | 1 хамрах хүрээ | - | Лабораторийн шалгалт баталгаажуулалтын хамрах хүрээ нэмэгдэнэ. | Геодезийн хэмжил зүйн лабораторийн итгэмжлэлийн хамрах хүрээний тодорхойлолтод электрон зай хэмжүүр (EDM)-ийн хэмжлийн нарийвчлалыг нэмж оруулсан. | 01.02-06.30 | 100 |

ГЕОДЕЗИЙН ХЭМЖИЛ ЗҮЙН ЛАБОРАТОРИЙН
ИТГЭМЖЛЭЛИЙН ХҮРЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

| Хэмжил зүйн үйл ажиллагааны чиглэл | Хэмжих хэрэгслийн нэр төрөл | Хэмжилтийн хязгаар | Зөвшөөрөгдөх алдаа нарийвчлалын анги | Шалгах аргын стандарт, НТББичгийн жагсаалт |
|---|---|---|---|---|
| Шугаман өнцгийн хэмжил: | | | | |
| Шалгалт баталгаажуулалт | Өндөр нарийвчлалын тоон нивелир | ≤150м | 1мм/км | Нивелирт шалгалт, тохируулга хийх аргачлал «ШТ-3.6» Барилга, хот байгуулалтын сайдын 2008 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 104 дугаар тушаал "Нивелир шалгалт, шинжилгээ хийх аргын заавар" БНбД-11-07-04:2008 MNS ISO 17123-2:2001 |
| | Нарийвчлалын автомат нивелир | ≤150м | (2÷10) мм/км | |
| | Техникийн оптик-механик нивелир | ≤150м | 10мм/км | |
| | Өндөр нарийвчлалын электрон теодолит | (0÷360)' | 2" | Теодолитод шалгалт, тохируулга хийх аргачлал. Барилга, хот байгуулалтын сайдын 2008 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 104 дугаар тушаалаар баталсан "Теодолитод шалгах, шинжлах аргын заавар" ГЗЗНбД-10-01-89:2008 ISO 17123-3:2001 |
| | Нарийвчлалын электрон теодолит | (0÷360)' | (2÷15)" | |
| | Техникийн оптик-механик теодолит | (0÷360)' | (15÷30)" | |
| | Өндөр нарийвчлалын электрон тахеометр | (0÷360)' | 1" | Электрон тахеометрт шалгалт, тохируулга хийх аргачлал. Оптик ба оптикийн багаж ISO 17123-3:2016 MNS ISO 17123-4:2016 |
| | | Зай (EDM) (20-2100м) | 1мм+1ppm x D | |
| | Нарийвчлалын электрон тахеометр | (0÷360)' | 2" | |
| | | Зай (EDM) (20-2100м) | 2мм+2ppm x D | |
| | Техникийн электрон тахеометр | (0÷360)' | (6÷15)" | |
| | | Зай (EDM) (20-2100м) | 6мм+5ppm x D | |
| | Лазер хэмжигч | ≤1,0мм | 1мм/30м | Лазер хэмжлийн багаж шалгах аргачлал. ISO 17123-6:2012. Оптик ба оптикийн багаж – Геодезийн ба зураглалын багажийг хээрийн нөхцөлд турших аргачлал – 9-р хэсэг: Газрын лазер сканер MNS ISO 17123-9:2016 |
| | Лазер сканер | ≤2000м | 2мм/км | |
| | Бүх төрлийн 2 долгионы GNSS-ийн хүлээн авагч | 1575.42 MHz (L1) 1227.60 MHz (L2) 1176.45 MHz (L5) | Статик хэмжилт: 2.5мм+1.0 ppm*RMS 5.0мм+1.0 ppm*RMS RTK хэмжилт: 8.0мм+1.0ppm*RMS 15.0мм+1.0ppm*RMS | Оптик ба оптикийн багаж – Геодезийн ба зураглалын багажны шалгалтын аргачлал – 8-р хэсэг: GNSS-ийн багажны бодит агшины кинематик (RTK) горимын хээрийн хэмжилтийн систем MNS ISO 17123-8:2016 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Арга хэмжээ 7. Геодезийн хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийхэд гүйцэтгэхэд орчны температур, чийг даралтын нөлөө /даралт, температур/ тооцох шаардлагатай. Иймд эдгээр нөхцлийг хянах бүртгэх баталгаатай хэмжих хэрэгсэл дутмаг байна. Нэг хэмжих хэрэгсэл байгаа боловч шалгалт тохируулгад хамрагдаагүй. | 2 ширхэг | 2022 онд зүүн заагуууртай орчны нөхцөл хэмжигч авсан. | MNS ISO/IEC 17025:2018 стандартын 6.3.5-т заасан шаардлагад нийцсэн байна. | Орчны нөхцөл хэмжих YEM-70AL-F маркийн 24080520182, 24080520174 тус тус хувийн дугаартай 2 ширхэг электрон барометр, термометр, чийгшил хэмжигчийг худалдан авч Цаг уур орчны шинжилгээний газрын Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторид шалгалт тохируулга, баталгаажуулалтад хамруулж Г-2025/10, Г-2025/11, АӨ-2025/843, АӨ-2025/844 дугаартай гэрчилгээ авсан.       | 01.02-06.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Арга хэмжээ 8. Дотоодын лаборатори хоорондын харьцуулалт зохион байгуулах | 1 удаа | - | БНХАУ-ын Үндэсний хэмжил зүйн хүрээлэнд 2025 оны 06 дугаар сард зохион байгуулагдах уртын зай хэмжүүр (EDM)-ийн төрлөөр олон улсын харьцуулалтад оролцох бэлтгэл ажил хангагдана. | Стандарт, хэмжил зүйн газраас Ази номхон далайн хэмжил зүйн байгууллага (АРМР)-ын хөгжиж буй орнуудыг дэмжих хорооны дэмжлэгтэй Уртын техникийн хорооны санаачилгаар БНХАУ-ын Үндэсний хэмжил зүйн хүрээлэнд 2025 оны 06 дугаар сард зохион байгуулагдах олон улсын харьцуулалтад уртын төрлөөр электрон зай хэмжүүр (EDM)-ээр манай байгууллагатай хамтран оролцох тухай 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр 01/142 дугаар албан бичиг ирүүлсэн.<br>Газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/147 тушаалаар Д.Алтантуулыг уртын хэмжлийн төрлөөр олон улсын харьцуулалтад оролцуулахаар болсон.<br>Манай лаборатори олон улсын харьцуулалтад оролцох бэлтгэл ажил хангах үүднээс стандарт, хэмжил зүйн газрын уртын эталоны лабораторийн мэргэжилтнүүдтэй хамтран электрон зай хэмжүүр (EDM)-ээр дотоодын харьцуулалтыг 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Төв аймгийн Номтын аманд байрлах "Жишилтийн полигон"-д зохион байгуулсан.<br>Хэмжилтийг БНХАУ-ын Үндэсний хэмжил зүйн хүрээлэнгээс ирүүлсэн электрон зай хэмжүүр (EDM)-ийн харьцуулалтын техникийн протоколын төсөлд заасны дагуу 7 багана хоорондын зайг хэмжиж, MNS ISO17123-4 :2016 стандартыг баримтлан тэгшитгэн бодолтыг хийж, хэмжлийн эргэлзээг тооцсон.<br>  | 01.02-06.30 | 100 |

## Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх, арга хэмжээний биелэлт

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Арга хэмжээ 2.1<br>Хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | - | Шинээр гарсан хууль, дүрэм, журам, тогтоол, шийдвэртэй тухай бүр танилцаж, судлах | Шинээр гарсан хууль, дүрэм, журам, тогтоол, шийдвэртэй тухай бүр танилцаж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн байна. | Хэмжил зүйн тухай хууль, Хэмжих хэрэгслийн загварыг турших журам судлав.<br>“Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”, MNS ISO 17043, MNS ISO 9001 стандартыг судлав. | 01.02-06.30 | 100 |
| 2 | Арга хэмжээ 2.2<br>Олон улсын харьцуулалтад оролцох бэлтгэл ажил | - | - | Олон улсын харьцуулалтад оролцогч орнуудын хэмжилтийн чадавхийг өгөгдөл болгон баталгаажуулах, стандартуудын дүйцэх түвшинг тогтооход явдал юм. | Олон улсын харьцуулалтад баримтлах дараах стандартыг орчуулж, судалсан.<br>1. ISO17123-1:2014 “Онол”;<br>2. JJG703-2003 “Электро-оптик зай хэмжүүр”;<br>3. MNS ISO 17043:2010 “Тохирлын үнэлгээ-Ур чадварын сорилтод тавих ерөнхий шаардлага”;<br>4. MNS ISO 17040:2007 “Тохирлын үнэлгээ-Тохирлын үнэлгээний болон итгэмжлэлийн байгууллагад хийх ижил төвшний үнэлгээнд тавих ерөнхий шаардлага”; | 01.02-06.30 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:
ГЕОДЕЗИЙН БАГАЖ БАТАЛГААЖУУЛАЛТ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Д.АЛТАНТУУЛ 2025.06.04

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*4 дүгээр хавсралт*

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГУУЛАХ ЯВЦЫН ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ (ЗАГВАР)

Албан хаагчийн овог, нэр: Д. Алтантуул

Ярилцлага хийсэн огноо: 20 25 оны 04 сарын 21 өдөр

Ярилцлагын хэлбэр: 1.Биечлэн 2.Утсаар 3.Цахим хэлбэрээр

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хангалтгүй буюу эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний тухай | Нэгжийн даргаас өгсөн үүрэг даалгавар |
|---|---|---|---|
| | **Зорилт .... “............................................................”** | | |
| 1. | Арга хэмжээ .... 2.5.1.3 | Лабораторийн итгэмжлэл сунгуулах | Үл бохирдол арилгах а/р-ийн төлөвлөгөөний хэрэгжилт рөнгүүлэх |
| 2. | Арга хэмжээ .... 2.5.1.1 | Нийтийн номын сан байгуулах | Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах |
| | **Зорилт .... “............................................................”** | | |
| 1. | Арга хэмжээ .... | | |
| 2. | Арга хэмжээ .... | | |
| | ………………….. | | |

**ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН:**

ГЗЗХ-ийн дарга .................... Д. Мөнхзаяа / Мөнхзаяа /

( Албан тушаал ) ( Нэр, гарын үсэг )